



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/63

Хэрлэн сум

“Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Хэнтий аймагт төлөөлөн гүйцэтгэх гэрээний 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчнийг орон нутаг, ард иргэдэд сурталчлах, иргэн цэргийн холбоог бэхжүүлэх зорилгоор “Монгол цэргийн өдөр”-ийг 2025 оны 03 дугаар сарын 11-ээс 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Монгол цэргийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Ойн арга хэмжээтэй холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, зэвсэгт, техникийн үзэсгэлэнг дэлгэж, орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудад өөрийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсугай.

4. Арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг зохион байгуулах комисст, арга хэмжээнд зохион байгуулалттай оролцохыг Чингис хотод үйл ажиллагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Д.АЮУРБУНЬ



$\frac{50}{\text{مستحق}}$
 $\frac{20}{\text{مستحق}}$
 $\frac{30}{\text{مستحق}}$

”يُصْرَتُهُمْ سَعْدًا مِنْ رَحْمَةٍ—يُصْرَتُهُمْ
مُسْتَعِينًا مِنْ رَحْمَةٍ



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 104 ЖИЛИЙН ОЙ,
“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга:	А.Жаргалсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Орлогч дарга:	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга, дэд хурандаа
Нарийн бичгийн дарга:	Б.Лхагвасамбуу	Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалт эрхэлсэн офицер ахлах дэслэгч
Гишүүд:	М.Бат-Очир	Зэвсэгт хүчний 232-р ангийн захирагч, хурандаа
	П.Мөнхбаатар	Хилийн цэргийн 0287-р ангийн захирагч хурандаа
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
	Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга, хурандаа
	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга, хурандаа
	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа
	Ц.Батсайхан	МЦНХ-ны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, бэлтгэл дэд хурандаа
	Г.Солонго	Биеийн тамир спортын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч



АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

3 дугаар сарын 10-ны Даваа гариг

18.00.Цэрэгжлийн спортын цогцолбор тэмцээний техникийн зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулах.

3 дугаар сарын 11-ны Мягмар гариг

10.00.Партизан Б.Пунцагийн хөшөөнд цэцэг өргөх ёслолын арга хэмжээ
(Зохион байгуулах комисс)

11.00.Гар бөмбөгийн тэмцээн (Цагдаагийн газар)

12.00.Пауэрлифтинг хүндийг өргөлтийн тэмцээн (Хадун фитнес клуб)

13.00.Удирдах бүрэлдэхүүний дунд зохион байгуулах “Дардс” шидэлтийн тэмцээн (Онцгой байдлын газар)

15.00.Гар дээр суниалтын тэмцээн (Тагнуулын хэлтэс)

15.00.Шатрын тэмцээн (Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар)

3 дугаар сарын 12-ны Лхагва гариг

10.00.Сүхбаатарын одонт хурандаа Ш.Дорж агсны нэрэмжит “Цэрэг эрс-2025/ марш тактикийн аварга тасаг шалгаруулах тэмцээний нээлтийн арга хэмжээ
(Чингисийн талбайд Зэвсэгт хүчний 232 дугаар анги)

15.00 Буудлагын тэмцээн (Хилийн цэргийн 0287 дугаар анги)

18.00 Дүн гаргаж шагнал гардуулах (Зохион байгуулах комисс)